



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-01, Факс: 32-70-16
E-mail: ariunzaya.a@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 06. 29 № чхх-03/786
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт.1.4.5.хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

О.БАТНАЙРАМДАЛ

Ж.ГАНБААТАР

М.ГАНХҮЛЭГ

Г.ОЧИРБАТ

Б.МӨНХСОЁЛ

А.УНДРАА

О.САРАНЧУЛУУН

Р.СЭДДОРЖ

00000108



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2026.05.24 № УИХ-03/6069
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль, тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт..166.хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

00000075



2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална” гэж заасны дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсрууллаа.

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 16-д “*Статистикийн тухай*” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэ зохицуулалтыг хуульд тусгах, боловсронгуй болгох” үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний статистикийн хороо тус тус хүлээсэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1-д “Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх зорилгын хүрээнд дараах үндсэн зорилт, үйл ажиллагаа хамаарна” гэсний дотор 2.1.1.1-д “Статистикийн тухай хууль, холбогдох бусад эрх зүйн актыг олон улсын тэргүүний туршлагад үндэслэн, статистикийн бие даасан байдал, албан ёсны статистикийн зарчмууд бүрэн тусгагдсан байхаар шинэчлэх” гэж тусгасан нь Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик шаардлага

Статистикийн тухай хуулийг анх 1994 онд баталж, 1997 онд шинэчлэн найруулж нийт 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд түүнээс хойш уг хуульд нийт 20 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулж, 2 зүйлийг шинээр нэмж, 1 зүйлийг хүчингүй болгосноор 24 зүйлийн 20 зүйлд нь буюу 83% хувь (дийлэнх хэсэг) нь өөрчлөгдөж, уг хууль батлагдах үеийн хуулийн хэрэгцээ, шаардлага, зохицуулах зүйл, тэдгээрийн үндэслэл болсон үзэл баримтлал нь хувирч, өөрчлөгдсөн байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь Хууль тогтоомжийн тухай хууль, үндэсний эрх зүйн тогтолцооны болон хууль зүйн техникийн хувьд, уг хуулиар зохицуулах харилцааны

эцэст үүсэх үр дагаварт эерэг нөлөөлөл үзүүлэхээр тооцогдож байсан хуулийн үзэл баримтлал бүрэн өөрчлөгдөж, нэгдсэн системчлэлгүй, тодорхой бус, ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байгаа учраас нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр тусгах боломжгүй болсон. Нөгөөтээгүүр тус хуулийг шинэчлэн найруулах дараах практик шаардлагууд бий болжээ. Үүнд:

1.2.1. Статистикийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр дагаварт үндэслэн статистикийн засаглал, хараат бус байдал, статистикийн мэдээллийн эх үүсвэр, тархаалт, ашиглалт, статистикийн үйл ажиллагааны чанарын хяналт, мэдээллийн нууцлал, хамгаалал, албан ёсны статистикийн 10 зарчмыг бүрэн тусгах, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээг хийх, (*Data science, Data governance*) зарим нэр томъёог шинэчлэх зэрэг асуудлыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах.

1.2.2. Статистикийн анхан, дунд шатны нэгжийн удирдах, гүйцэтгэх ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр гарсан Статистикийн тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй сорилтуудын талаарх саналууд зохих нөлөөлөл үзүүлээ. Уулзалтад үг хэлж, санал гаргасан ажилтан бүр (оролцсон ажилтнуудын дийлэнх)-ийн одоогийн хууль тогтоомжийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, сайжруулах, ялангуяа бие даасан, хараат бус байдал, төсвийн асуудал болон мэдээллийг иргэн хуулийн этгээдээс авах арга, журмыг өөрчлөх, "албадлагын" арга хэрэгсэл ашиглах зэрэг асуудлыг хуулийн төсөлд тусгах гэсэн саналууд давтагдаж байсныг энд дурдах нь зүйтэй.

1.2.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 8.1.7, 9.7.1 дэх заалтад Үндэсний статистикийн хорооны хариуцах нэмэлт чиг үүрэг тусгагдсан, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин" урт хугацааны бодлогын баримт бичиг нь Үндэсний статистикийн хорооны одоогийн зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ, арга хэрэгсэл, журам, тэдгээрт шууд холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахад Статистикийн тухай хуулийг шинэчлэн найруулах үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлтийн үндэслэл болсон.

1.2.4. Статистикийн мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, тархаах харилцаанд Статистикийн тухай хуулиас гадна нийт 15 хууль дангаар болон дам байдлаар хамардаг, Монгол Улсын Их Хурлын 15 тогтоол, Засгийн газрын 11 тогтоол, Үндэсний статистикийн хороо, бусад нэр бүхий субъекттэй хамтран баталсан 6 шийдвэр, Үндэсний статистикийн хорооны даргын дангаар баталсан 11 шийдвэр, нийт 58 эрх зүйн баримт бичгийн хүрээнд статистикийн эрх зүйн харилцааг зохицуулж байна. Тиймээс шинэчилсэн найруулгын төсөлд эдгээрийг нэгтгэн системчлэх, хууль зүйн үндэслэлийг нь тусгах замаар давхардал, хийдлийг арилгах, ойлгомжтой, оновчтой болгох шаардлага байгаа бөгөөд нэгэнт хэрэгжсэн болон хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлага, дэвшүүлж байгаа цаг үеийн харилцаанаас хамаарч зарим эрх зүйн актыг хүчингүй болгох талаар санал гаргахад ч дээрх байдал нөлөөллөө.

1.2.5. Монгол Улсын Үндэсний статистикийн системд Олон улсын цогц үнэлгээ (ОУЦҮ)-г Европын Чөлөөт Худалдааны Ассоциац (ЕЧХА), НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) болон НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (НҮБ-ын ЕЭЗК) хамтран 2024 оны 5 дугаар сард хийж, Статистикийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох хууль тогтоомжуудыг судалж, Статистикийн тухай хуулийг бүхэлд нь шинэчлэх

шаардлагатай гэж дүгнэсэн байна. Үнэлгээний баг статистикийн хууль эрх зүй, бүтэц тогтолцооны хүрээнд дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

- Үндэсний статистикийн систем (ҮСС)-ийн хамрах хүрээ, бүтцийг НҮБ-ын Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд, Европын статистикийн үйл ажиллагааны хуулийн зарим холбогдох заалтуудтай уялдуулан, шаардлагатай тохиолдолд холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актад өөрчлөлт хийх шаардлагатай (Хүн ам орон сууцны тооллогын тухай хууль гэх мэт);
- Одоогийн мөрдөж байгаа Статистикийн тухай хуульд тусгасан захиргааны мэдээлэл эрхлэн гаргагчид, захиргааны мэдээллийг эзэмшигч болон статистикийн байгууллагын үүрэг, статистикийн зорилгоор мэдээлэл олж авах, мэдээллийн санд хандах эрх гэсэн заалтуудыг илүү тодорхой болгох;
- Статистикийн тухай хууль Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээний талаар тодорхой заалт оруулах шаардлагатай. Энэ нь Статистикийн тухай хууль болон Үндэсний статистикийн систем (ҮСС)-ийн үндэс болно.

1.2.6. Дэлхийн ихэнх улс орнууд үүний дотор манай улстай ижил хуулийн систем (Роман-Германы хуулийн систем)-тэй, өндөр хөгжилтэй болон Ази, Номхон бүсийн улс орнуудыг судалж үзэхэд статистикийн үйл ажиллагааг тусгайлсан хуулиар зохицуулж, Албан ёсны статистикийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэн бие даасан, хараат бус байдлаа хангаж байгаа нийтлэг байдал нь Статистикийн тухай хуулийг шинэчлэх нэг практик шаардлага болж байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Статистикийн тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад өөрчлөлт гарч нийт заалтын тавь /1997-2021 онд 270/121 заалтад нэмэлт, өөрчлөлт орсон/-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа, уг хуульд

- 20 удаа нэмэлт оруулж;
- 125 удаа өөрчлөлт оруулж;
- 16 удаа өөрчлөн найруулж;
- 6 удаа хасаж;
- 10 удаа зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгож,

нийт 178 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Эдгээр нь хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалтын дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгав. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, статистикийн хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын талаар;

Хоёрдугаар бүлэгт статистикийн тогтолцоо, Үндэсний статистикийн хорооны бүрэн эрх түүний дотор холбогдох байгууллагуудын мэдээллийн санд хандах эрх, хорооны чиг үүрэг, дарга, дэд даргын бүрэн эрх, үндэсний статистикийн зөвлөл, түүний бүрэн эрх, эрхлэх асуудлыг тодорхой тусгах, үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга, статистикийн нэгжүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, эрсдэлийн удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинээр томъёолж, бусад оролцогч талууд, анхан шатны нэгжийн статистикийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар;

Гуравдугаар бүлэгт статистикийн мэдээллийн хэлбэр, албан ёсны статистик мэдээллийн үзүүлэлт, статистик мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийг нууцлалыг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар;

Дөрөвдүгээр бүлэгт статистикийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа, статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах, нийтэд түгээх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, статистикийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа, статистикийн үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар;

Тавдугаар бүлэгт статистикийн мэдээллийн чанарын хяналтын тогтолцоо, статистикийн мэдээллийн чанарын дотоод хяналтын үр дагаврын талаар;

Зургаадугаар бүлэгт статистикийн мэдээлэгч, түүний эрх, үүрэг, статистик мэдээлэл хэрэглэгчийн эрх, үүрэг, мэдээлэгчийн хуулиар тогтоосон нууцын хамгаалалт, статистикийн үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн Засаг даргын оролцоо, статистикийн үйл ажиллагааны талаар сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын оролцоо, статистикийн үйл ажиллагааны талаар төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн оролцоо, албан ёсны статистикийн үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрхийн талаар;

Долоодугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тус тусгаж, нийт 35 зүйлтэй байхаар төслийг боловсруулав.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт хэт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Мөн одоогийн мөрдөж байгаа хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл арилж, хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж урьдчилан тооцоолж байна. Үүнд:

- 3.1. Хуулийн нэр томъёо, нэр томъёоны тодорхойлолтоор дамжуулан статистикийн мэдээллийн хэлбэр, түүнчлэн агуулга, зохицуулалт тодорхой болно;
- 3.2. Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим хууль, түүний заалтыг хүчингүй болгосноор хуулийн давхардал арилахын зэрэгцээ өмнө нь эрх зүйн хийдэл буюу тодорхой бус зохицуулалтаас үүсэж байсан хүндрэлтэй асуудлууд нэг мөр болно;
- 3.3. Үндэсний статистикийн хороо нь албан ёсны болон захиргааны статистик үзүүлэлтүүдийг тогтоох болсноор энэ зорилгоор олон удаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байдлыг халж, эрх зүйн тогтвортой орчин бий болно;
- 3.4. Статистикийн эрх зүйн харилцаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн болон иргэдийн оролцоо хангагдаж тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага тодорхой болно;
- 3.5. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах албан ёсны статистикийн

- мэдээллийг цуглуулах, боловсруулах, эрх зүйн орчин бүрдэж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шийдвэрийн үндэс болно;
- 3.6. Төрийн болон бусад байгууллагын мэдээллийн санд хандах, тэдгээрийг ашиглах, мэдээллийн олон эх үүсвэр ашиглах эрх зүйн орчин бүрдэнэ;
- 3.7. Статистикийн засаглалын асуудал тогтолцооны түвшинд шийдвэрлэгдэж, ингэснээр статистикийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал эрх зүйн хүрээнд бэхжиж, тодорхойлогдоно;
- 3.8. Статистикийн мэдээллийн эх үүсвэр, тархаалт, ашиглалт, чанарын хяналт, мэдээллийн нууцлал, хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, албан ёсны статистикийн зарчмуудыг үйл ажиллагааны үндэс болгох, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээний (Data science, Data governance) зохицуулалтыг бүрдүүлж, төрийн их өгөгдлийн хэрэгжилтийг хангуулах эрх зүйн орчин бүрдэх.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол улсын хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Төв банкны тухай, Төрийн албаны тухай, Яамны эрх зүйн байдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, төслүүд болон Статистикийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

___ оОо ___

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА (Товч)

Статистикийн тухай хууль нь анх 1994 онд батлагдсан бөгөөд 1997 онд шинэчилсэн найруулга хэлбэрээр батлагдаж, түүнээс хойш өнөөдрийг хүртэл 28 дахь жилдээ үйлчилж байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Статистикийн тухай хууль нь 1997 онд нийт 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд түүнээс хойш уг хуульд нийт **20** удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, **2** зүйлийг шинээр нэмж, **1** зүйлийг хүчингүй болгосноор **24** зүйлтэй болж, энэхүү **24** зүйлийн **20** зүйлд нь буюу **83% хувь** (дийлэнх хэсэг) нь өөрчлөгдөж, 1997 онд уг хууль батлагдах үеийн хуулийн хэрэгцээ, шаардлага, зохицуулах зүйл, тэдгээрийн үндэслэл болсон үзэл баримтлал нь хувирч, өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь цаашид хүлээгдэж байгаа зохицуулах шаардлагатай харилцааг бүрэн зохицуулах боломжгүй болсон.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, үндэсний эрх зүйн тогтолцооны болон хууль зүйн техникийн хувьд, уг хуулиар зохицуулах харилцааны эцэст үүсэх үр дагаварт эерэг нөлөөлөл үзүүлэхээр тооцогдож байсан хуулийн үзэл баримтлал бүрэн өөрчлөгдөж, нэгдсэн системчлэлгүй, тодорхой бус, ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байгаа учраас Статистикийн тухай хуульд Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний төлөвлөлтөд тусгасан асуудлууд, олон улсын жишиг, тэргүүн туршлагыг нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр тусгах боломжгүй байна.

Статистикийн эрх зүйн харилцаанд холбогдох цөөнгүй хууль тогтоомж үйлчилж байгаа нь шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах бас нэгэн үндэслэл боллоо. Тухайлбал, статистикийн мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, тархаах харилцаанд Статистикийн тухай хуулиас гадна нийт **15** хууль дангаар болон дам шинжтэй, иш татан үйлчилж байна.

Эдгээр хуулиудаас гадна Монгол Улсын Их Хурлын 15 тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 11 тогтоол, ҮСХ-ноос бусад нэр бүхий субъекттэй хамтран баталсан 6 шийдвэр, ҮСХ-ны даргын дангаар баталсан 11 шийдвэр, **нийт 58 хууль тогтоомж**, бусад тогтоол, шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хүрээнд статистикийн эрх зүйн харилцааг зохицуулж байна. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай", "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай", "Кибер аюулгүй байдлын тухай", "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийн зэрэг хуулийн хэрэгжилт болон хууль хоорондын уялдаа холбоог хангах, бусад холбогдох хуульд нийцүүлэх шаардлага үүссэн.

Тиймээс шинэчилсэн найруулгын төсөлд эдгээрийг нэгтгэн системчлэх, хууль зүйн үндэслэлийг нь тусгах замаар давхардал, хийдлийг арилгах, ойлгомжтой, оновчтой болгох шаардлага гарч байгаа бөгөөд нэгэнт хэрэгжсэн болон хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлага, дэвшүүлж байгаа цаг үеийн харилцаанаас хамаарч зарим эрх зүйн актыг хүчингүй болгох талаар санал гаргахад ч дээрх байдал нөлөөллөө.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, статистикийн хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын талаар;

Хоёрдугаар бүлэгт статистикийн тогтолцоо, Үндэсний статистикийн хорооны бүрэн эрх түүний дотор холбогдох байгууллагуудын мэдээллийн санд хандах эрх, хорооны чиг үүрэг, дарга, дэд даргын бүрэн эрх, үндэсний статистикийн зөвлөл, түүний бүрэн эрх, эрхлэх асуудлыг тодорхой тусгах, үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга, статистикийн нэгжүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, эрсдэлийн удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинээр томъёолж, бусад оролцогч талууд, анхан шатны нэгжийн статистикийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар;

Гуравдугаар бүлэгт статистикийн мэдээллийн хэлбэр, албан ёсны статистик мэдээллийн үзүүлэлт, статистик мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийг нууцлалыг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар;

Дөрөвдүгээр бүлэгт статистикийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа, статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах, нийтэд түгээх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт, статистикийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа, статистикийн улсын байцаагч, түүний эрх зүйн байдал, статистикийн үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар;

Тавдугаар бүлэгт статистикийн мэдээллийн чанарын хяналтын тогтолцоо, статистикийн мэдээллийн чанарын дотоод хяналтын үр дагаврын талаар;

Зургаадугаар бүлэгт статистикийн мэдээлэгч, түүний эрх, үүрэг, статистик мэдээлэл хэрэглэгчийн эрх, үүрэг, мэдээлэгчийн хуулиар тогтоосон нууцын хамгаалалт, статистикийн үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн Засаг даргын оролцоо, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын оролцоо, төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн оролцоо, албан ёсны статистикийн үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрхийн талаар;

Долоодугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тус тусгаж, нийт 35 зүйлтэй байхаар төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт хэт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Мөн одоогийн мөрдөж байгаа хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл арилж, хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж урьдчилан тооцоолж байна. Үүнд:

1. Хуулийн нэр томьёо, нэр томьёоны тодорхойлолтоор дамжуулан статистикийн мэдээллийн хэлбэр, түүнчлэн агуулга, зохицуулалт тодорхой болно;
2. Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, **зарим хууль, түүний заалтыг хүчингүй болгосноор** хуулийн давхардал арилахын зэрэгцээ өмнө нь эрх зүйн хийдэл буюу тодорхой бус зохицуулалтаас үүсэж байсан хүндрэлтэй асуудлууд нэг мөр болно;
3. Үндэсний статистикийн хороо нь албан ёсны болон захиргааны статистик үзүүлэлтүүдийг тогтоох болсноор энэ зорилгоор олон удаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байдлыг халж, эрх зүйн тогтвортой орчин бий болно;
4. Статистикийн эрх зүйн харилцаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн болон иргэдийн оролцоо хангагдаж тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага тодорхой болно;
5. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, эрх зүйн орчин бүрдэж, их өгөгдөлд суурилсан урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шийдвэр гаргах үндэс болно;
6. Төрийн болон бусад байгууллагын мэдээллийн санд хандах, тэдгээрийг ашиглах, мэдээллийн олон эх үүсвэр ашиглах эрх зүйн орчин бүрдэнэ;
7. Статистикийн засаглалын асуудал тогтолцооны түвшинд шийдвэрлэгдэж, ингэснээр статистикийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал эрх зүйн хүрээнд бэхжиж, тодорхойлогдоно;
8. Статистикийн мэдээллийн эх үүсвэр, тархаалт, ашиглалт, чанарын хяналт, мэдээллийн нууцлал, хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, албан ёсны статистикийн зарчмуудыг үйл ажиллагааны үндэс болгох, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээний (Data science, Data governance) зохицуулалтыг бүрдүүлж, төрийн их өгөгдлийн хэрэгжилтийг хангуулах эрх зүйн орчин бүрдэх зэрэг болно.

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**
(Дэлгэрэнгүй)

Үндэсний статистикийн хорооны чиг үүргийг,

- 1) Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1.7-д “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.”¹ гэж;
- 2) Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.1 дэх заалтад “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх,” гэж;
- 3) мөн хуулийн 9.7.2 дахь заалтад “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах,” гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн Статистикийн тухай хуулийг боловсронгуй болгох, шинэчлэх талаар Монгол Улсын Их Хурлаас дараах тогтоолууд гарч байсан. Үүнд:

- 1) УИХ-ын 2017 оны “**Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай**” 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “**Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл**”-ийн 16-д “**Статистикийн тухай**” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэ зохицуулалтыг хуульд тусгах, боловсронгуй болгох” үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний статистикийн хороо тус тус хүлээсэн;
- 2) Монгол Улсын Их Хурлын 2017 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “**Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр**”-ийн 2.1-д “Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх зорилгын хүрээнд дараахь үндсэн зорилт, үйл ажиллагаа хамаарна:” гэсний дотор 2.1.1.1-д “**Статистикийн тухай хууль**, холбогдох бусад эрх зүйн актыг олон улсын тэргүүний туршлагад үндэслэн, статистикийн бие даасан байдал, албан ёсны статистикийн зарчмууд бүрэн тусгагдсан байхаар шинэчлэх” гэж тусгагдсан бөгөөд эдгээр тогтоолууд нь Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль зүйн шууд үндэслэл болж байна.

Статистикийн тухай хууль нь анх 1994 онд батлагдсан бөгөөд 1997 онд шинэчилсэн найруулга хэлбэрээр батлагдаж, түүнээс хойш өнөөдрийг хүртэл 28 дахь жилдээ үйлчилж байна.

¹ 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Статистикийн тухай хуульд 1999, 2003, 2004, 2008, 2011, 2012, 2013, 2014, 2015, 2016, 2017, 2019, 2021, 2022, 2023, 2024 онуудад нэмэлт, өөрчлөлт оржээ. Дээрх байдлуудтай холбогдуулан Статистикийн тухай хуулийг шинэчлэн найруулах дараах шаардлага үүслээ. Үүнд:

1. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Статистикийн тухай хууль нь 1997 онд нийт 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд түүнээс хойш уг хуульд нийт **20** удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, **2** зүйлийг шинээр нэмж, **1** зүйлийг хүчингүй болгосноор **24** зүйлтэй болж, энэхүү **24** зүйлийн **20** зүйлд нь буюу 83% хувь (дийлэнх хэсэг) нь өөрчлөгдөж, 1997 онд уг хууль батлагдах үеийн хуулийн хэрэгцээ, шаардлага, зохицуулах зүйл, тэдгээрийн үндэслэл болсон үзэл баримтлал нь хувирч, өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь цаашид хүлээгдэж байгаа зохицуулах шаардлагатай харилцааг бүрэн зохицуулах боломжгүй. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, үндэсний эрх зүйн тогтолцооны болон хууль зүйн техникийн хувьд, уг хуулиар зохицуулах харилцааны эцэст үүсэх үр дагаварт эерэг нөлөөлөл үзүүлэхээр тооцогдож байсан хуулийн үзэл баримтлал бүрэн өөрчлөгдөж, нэгдсэн системчлэлгүй, тодорхой бус, ойлгомжгүй байдлыг үүсгэхээр байгаа учраас Статистикийн тухай хуульд Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний төлөвлөлтөд тусгасан асуудлууд, олон улсын жишиг, тэргүүн туршлагыг нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр тусгах боломжгүй байна.
2. Статистикийн эрх зүйн харилцаанд холбогдох цөөнгүй хууль тогтоомж үйлчилж байгаа нь шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах бас нэгэн үндэслэл боллоо. Статистикийн мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, тархаах харилцаанд Статистикийн тухай хуулиас гадна нийт **15** хууль дангаар болон дам шинжтэй, иш татан үйлчилж байна. Үүнд:
 1. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай;
 2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
 3. Улсын бүртгэлийн ерөнхий хууль;
 4. Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль;
 5. Барилгын тухай хууль;
 6. Төрийн албаны тухай;
 7. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль;
 8. Малын генетик нөөцийн тухай хууль;
 9. Төсвийн тухай хууль;
 10. Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль /"Монгол Улсын Үндэсний статистикийн системийг сайжруулах төсөл"/;
 11. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
 12. Зөрчлийн тухай хууль;
 13. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
 14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
 15. Өрийн тухай хууль.

Эдгээр хуулиудаас гадна Монгол Улсын Их Хурлын 15 тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 11 тогтоол, ҮСХ-ноос бусад нэр бүхий субьекттэй хамтран баталсан 6 шийдвэр, ҮСХ-ны даргын дангаар баталсан 11 шийдвэр, нийт 58 хууль тогтоомж, бусад тогтоол, шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хүрээнд статистикийн эрх зүйн харилцааг зохицуулж байна. Тиймээс шинэчилсэн найруулгын төсөлд эдгээрийг нэгтгэн системчлэх, хууль зүйн үндэслэлийг нь тусгах замаар давхардал, хийдлийг арилгах, ойлгомжтой, оновчтой болгох шаардлага гарч байгаа бөгөөд нэгэнт хэрэгжсэн болон хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ шаардлага, дэвшүүлж байгаа цаг үеийн

харилцаанаас хамаарч зарим эрх зүйн актыг хүчингүй болгох талаар санал гаргахад ч дээрх байдал нөлөөллөө.

3. Үндэсний статистикийн хорооны удирдлага Статистикийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, туршлага, түүний үр дагаварт үндэслэн дараах саналуудыг гаргалаа. Тухайлбал, нэр томьёог шинэчлэх, статистикийн засаглал, бие даасан хараат бус байдал, статистикийн мэдээллийн эх үүсвэр, тархаалт, ашиглалт, статистикийн үйл ажиллагааны чанарын хяналт, мэдээллийн нууцлал, хамгаалал, албан ёсны статистикийн 10 зарчмыг бүрэн тусгах, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээний төв (Data science, Data governance) байгуулах зэрэг асуудлыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах тусгайлсан санал гаргасан юм.
4. Статистикийн анхан, дунд шатны нэгжийн удирдах, гүйцэтгэх ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр гарсан Статистикийн тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй сорилтуудын талаарх саналууд зохих нөлөөлөл үзүүллээ. Уулзалтад үг хэлж, санал гаргасан ажилтан бүр (оролцсон ажилтнуудын дийлэнх)-ийн одоогийн хууль тогтоомжийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, сайжруулах, ялангуяа бие даасан, хараат бус байдал, төсвийн асуудал болон мэдээллийг иргэн хуулийн этгээдээс авах арга, журмыг өөрчлөх, “албадлагын” арга хэрэгсэл ашиглах зэрэг асуудлыг хуулийн төсөлд нэмж тусгах гэсэн саналууд давтагдаж байсныг энд дурдах нь зүйтэй.
5. Цаг хугацааны хувьд тавигдаж байгаа сорилт, түүнийг шийдвэрлэх хууль зүйн өөрчлөлтөөс гадна Монгол Улсын хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хууль тогтоомжоор бэхжүүлсэн нь 1997 онд батлагдсан Статистикийн тухай хуульд үзэл баримтлалын шинжтэй зарчмын өөрчлөлт оруулах хэрэгцээг үүсгэж, шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах өөр нэгэн үндэслэл боллоо. Эдгээр баримт бичгүүдэд **Үндэсний статистикийн хорооны хариуцах чиг үүргийг тусгасан байдал нь** ҮСХ-ны одоогийн зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ, арга хэрэгсэл, журам, тэдгээрт шууд холбоотой асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах өөрөөр хэлбэл Статистикийн тухай хуулийг шинэчлэн найруулах үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлтийн үндэслэл болсон. Үүнд:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд доор дурдсан оролцогч оролцоно:
 - 8.1.7. *Үндэсний статистикийн хороо;*”
2. 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт “Үндэсний статистикийн хорооны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:
 - 9.7.1. *хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;*
3. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”,
4. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”,
5. УИХ-ын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын **1 дүгээр** хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,

6. УИХ-ын 2020 оны 23 дугаартай “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”.

6. Монгол Улсын Үндэсний статистикийн систем (ҮСС)-д Олон улсын цогц үнэлгээ (ОУЦҮ эсвэл Үнэлгээ)-г Европын Чөлөөт Худалдааны Ассоциац (ЕЧХА), НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) болон НҮБ-ын Европын Эдийн засгийн комисс (НҮБ-ын ЕЭЗК) хамтран хийж, Статистикийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан холбогдох хууль тогтоомжуудыг судалж, Статистикийн тухай хуулийг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Үнэлгээний баг статистикийн хууль эрх зүй, бүтэц тогтолцооны хүрээнд дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд:

1. Үндэсний статистикийн систем (ҮСС)-ийн хамрах хүрээ, бүтцийг НҮБ-ын Албан ёсны статистикийн үндсэн зарчмууд, Европын статистикийн үйл ажиллагааны хуулийн зарим холбогдох заалтуудтай уялдуулан, шаардлагатай тохиолдолд холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актад өөрчлөлт хийх шаардлагатай (Хүн ам орон сууцны тооллогын тухай хууль гэх мэт).
2. Одоогийн мөрдөж байгаа Статистикийн тухай хуульд тусгасан захиргааны мэдээлэл эрхлэн гаргагчид, захиргааны мэдээллийг эзэмшигч болон статистикийн байгууллагын үүрэг, статистикийн зорилгоор мэдээлэл олж авах, мэдээллийн санд хандах эрх гэсэн заалтуудыг илүү тодорхой болгох
3. Статистикийн тухай хуулинд Монгол Улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээний талаар тодорхой заалт оруулах шаардлагатай. Энэ нь Статистикийн тухай хууль болон Үндэсний статистикийн систем (ҮСС)-ийн үндэс болно.

7. Дэлхийн ихэнх улс орнууд үүний дотор манай улстай ижил хуулийн систем (Роман-Германы хуулийн систем)-тэй, өндөр хөгжилтэй болон Ази, Номхон бүсийн улс орнуудыг судалж үзэхэд статистикийн үйл ажиллагааг тусгайлсан хуулиар зохицуулж, Албан ёсны статистикийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэн бие даасан, хараат бус байдлаа хангаж байгаа нийтлэг байдал нь Статистикийн тухай хуулийг шинэчлэх нэг практик шаардлага болж байна.

Өмнө нь дурдсанчлан Статистикийн тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад өөрчлөлт гарч нийт заалтын тавь /1997-2021 онд 270/121 заалтад нэмэлт, өөрчлөлт орсон/-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа, уг хуульд

- 20 удаа нэмэлт оруулж;
- 125 удаа өөрчлөлт оруулж;
- 16 удаа өөрчлөн найруулж;
- 6 удаа хасч;
- 10 удаа зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгож,

нийт 178 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ. Эдгээр нь хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалтын дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсрууллаа.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгалаа. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, статистикийн хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын талаар;

Хоёрдугаар бүлэгт статистикийн тогтолцоо, Үндэсний статистикийн хорооны бүрэн эрх түүний дотор холбогдох байгууллагуудын мэдээллийн санд хандах эрх, хорооны чиг үүрэг, дарга, дэд даргын бүрэн эрх, үндэсний статистикийн зөвлөл, түүний бүрэн эрх, эрхлэх асуудлыг тодорхой тусгах, үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга, статистикийн нэгжүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, эрсдэлийн удирдлагатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинээр томъёолж, бусад оролцогч талууд, анхан шатны нэгжийн статистикийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар;

Гуравдугаар бүлэгт статистикийн мэдээллийн хэлбэр, албан ёсны статистик мэдээллийн үзүүлэлт, статистик мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийг нууцлалыг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар;

Дөрөвдүгээр бүлэгт статистикийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа, статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах, нийтэд түгээх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох, ашиг сонирхолын зөрчлийн зохицуулалт, статистикийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа, статистикийн үйл ажиллагаанд хориглох зүйлийн талаар;

Тавдугаар бүлэгт статистикийн мэдээллийн чанарын хяналтын тогтолцоо, статистикийн мэдээллийн чанарын дотоод хяналтын үр дагаварын талаар;

Зургаадугаар бүлэгт статистикийн мэдээлэгч, түүний эрх, үүрэг, статистик мэдээлэл хэрэглэгчийн эрх, үүрэг, мэдээлэгчийн хуулиар тогтоосон нууцын хамгаалалт, статистикийн үйл ажиллагааны талаар аймаг, нийслэлийн Засаг даргын оролцоо, статистикийн үйл ажиллагааны талаар сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын оролцоо, статистикийн үйл ажиллагааны талаар төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн оролцоо, албан ёсны статистикийн үйл ажиллагааны талаарх Засгийн газрын бүрэн эрхийн талаар;

Долоодугаар бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох талаар тус тусгаж, нийт 35 зүйлтэй байхаар төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт хэт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Мөн одоогийн мөрдөж байгаа хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл арилж, хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж урьдчилан тооцоолж байна. Үүнд:

1. Хуулийн нэр томъёо, нэр томъёоны тодорхойлолтоор дамжуулан статистикийн мэдээллийн хэлбэр, түүнчлэн агуулга, зохицуулалт тодорхой болно;
2. Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, зарим хууль, түүний заалтыг хүчингүй болгосноор хуулийн давхардал арилахын зэрэгцээ өмнө нь эрх зүйн хийдэл буюу тодорхой бус зохицуулалтаас үүсч байсан хүндрэлтэй асуудлууд нэг мөр болно;
3. Үндэсний статистикийн хороо нь албан ёсны болон захиргааны статистик үзүүлэлтүүдийг тогтоох болсноор энэ зорилгоор олон удаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байдлыг халж, эрх зүйн тогтвортой орчин бий болно;
4. Статистикийн эрх зүйн харилцаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн болон иргэдийн оролцоо хангагдаж тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлага тодорхой болно;
5. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийхэд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, эрх зүйн орчин бүрдэж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн шийдвэрийн үндэс болно;

6. Төрийн болон бусад байгууллагын мэдээллийн санд хандах, тэдгээрийг ашиглах, мэдээллийн олон эх үүсвэр ашиглах эрх зүйн орчин бүрдэнэ;
7. Статистикийн засаглалын асуудал тогтолцооны түвшинд шийдвэрлэгдэж, ингэснээр статистикийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал эрх зүйн хүрээнд бэхжиж, тодорхойлогдоно;
8. Статистикийн мэдээллийн эх үүсвэр, тархаалт, ашиглалт, чанарын хяналт, мэдээллийн нууцлал, хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, албан ёсны статистикийн зарчмуудыг үйл ажиллагааны үндэс болгох, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээний (Data science, Data governance) зохицуулалтыг бүрдүүлж, төрийн их өгөгдлийн хэрэгжилтийг хангуулах эрх зүйн орчин бүрдэх зэрэг болно.

___ оОо ___

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20 ... оны .. дугаар
сарын .. -ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь үндэсний статистикийн тогтолцоо, статистикийн үйл ажиллагааны зохион байгуулалт, статистикийн байгууллагын бүрэн эрх, хараат бус байдал, статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, тархаах, мэдээллийн чанар, нууцлал, аюулгүй байдал, мэдээлэгч, хэрэглэгч болон статистикийн үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Статистикийн тухай хууль тогтоомж

2.1.Статистикийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль², Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай³, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль⁴, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль⁵, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль⁶, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“албан ёсны статистикийн мэдээлэл” гэж энэ хуульд заасан журмаар батлагдсан аргачлал, ангилал, үзүүлэлт, мэргэжлийн стандартын дагуу боловсруулж, баталгаажуулсан, нийтэд тархаах зориулалттай статистикийн мэдээллийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

² Хүн ам, орон сууцны тооллогын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 04 дугаарт нийтлэгдсэн.

³ Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль, 1998 он

⁴ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

3.1.2.“албан бус статистикийн мэдээлэл” гэж хүн, хуулийн этгээдээс зорилго, аргачлалаа өөрөө тодорхойлж цуглуулсан, хувиргасан, боловсруулсан, нийтэд тархаасан мэдээллийг;

3.1.3.“албан ёсны статистикийн хөтөлбөр” гэж үндэсний статистикийн тогтолцоог хөгжүүлэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, албан ёсны статистикийн мэдээллийн хүрээ, үндсэн болон дэд үзүүлэлт, мэдээллийн эх үүсвэр, аргачлал, мэдээлэл эрхлэн гаргах байгууллага, гаргах давтамж, нийтлэх хугацаа, өгөгдлийн засаглал, чанар, нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг дунд хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх баримт бичгийг;

3.1.4.“анхдагч өгөгдөл” гэж мэдээлэгчээс шууд цуглуулсан, эсхүл мэдээллийн сан, бүртгэл, тооллого, судалгаанаас нэгж түвшинд олж авсан, статистикийн мэдээлэл боловсруулах эх өгөгдлийг;

3.1.5.“аюулгүй судалгааны орчин” гэж анхдагч өгөгдөл болон микро өгөгдлийг зөвшөөрөгдсөн судлаач зөвхөн батлагдсан судалгааны зорилгоор ашиглах, хандалт, боловсруулалт, гаралтын хяналт, аудитын бүртгэл, нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим болон биет орчныг;

3.1.6.“захиргааны мэдээлэл” гэж төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуульд заасан мэдээлэл хариуцагч эрхлэх асуудлынхаа хүрээнд үүсгэж, бүрдүүлж, хөтөлж байгаа бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг;

3.1.7.“мета өгөгдөл” гэж статистикийн өгөгдөл, мэдээллийн эх үүсвэр, бүтэц, тодорхойлолт, ангилал, аргачлал, хамрах хүрээ, чанар, шинэчлэлт, өөрчлөлтийн талаар тайлбарласан өгөгдлийг;

3.1.8.“мэдээлэл хариуцагч” гэж хуульд заасан чиг үүргийн хүрээнд статистикийн зорилгоор ашиглах өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж, хөтөлж, хадгалж, хамгаалж байгаа төрийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд болон хуульд заасан бусад этгээдийг;

3.1.9.“статистикийн байгууллага” гэж энэ хуульд заасан журмаар байгуулагдсан Үндэсний статистикийн хороо, түүний харьяа болон орон нутгийн статистикийн нэгжийг;

3.1.10.“статистикийн мэдээлэл” гэж энэ хуульд заасан журмаар цуглуулж, боловсруулсан албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны мэдээллийг;

3.1.11.“статистикийн мэдээлэгч” гэж энэ хуульд заасан статистикийн өгөгдөл, мэдээллийг гаргаж өгөх үүрэг бүхий хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг;

3.1.12.“статистикийн мэдээллийг хэрэглэгч” гэж статистикийн мэдээллийг хүлээн авч, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг;

3.1.13.“статистикийн мэдээллийн сан” гэж статистикийн зорилгоор үүсгэсэн, нэгтгэсэн, хадгалсан, хамгаалсан өгөгдөл, мэдээллийн санг;

3.1.14.“статистикийн мэдээллийн эх үүсвэр” гэж статистикийн мэдээлэл боловсруулахад ашиглах мэдээлэгч, захиргааны мэдээллийн сан, бүртгэл, тооллого, судалгаа болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.2, 27.4-д заасан мэдээллийн сан, бусад хууль ёсны өгөгдлийн эх үүсвэрийг;

3.1.15.“статистикийн өгөгдөл” гэж статистикийн зорилгоор цуглуулсан, олж авсан, эсхүл статистикийн мэдээлэл боловсруулахад ашиглах тоон, тэмдэгт болон бусад хэлбэрийн өгөгдлийг;

3.1.16. “статистикийн үйл ажиллагаа” гэж статистикийн мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, хүлээн авах, дамжуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, хадгалах, хамгаалах, үр дүнг тархаах цогц ажиллагааг;

3.1.17. “статистикийн тооллого” гэж судалгааны эх олонлогийг бүхэлд нь хамруулан анхдагч мэдээлэл цуглуулах статистикийн ажиглалтыг;

3.1.18. “статистикийн түүвэр судалгаа” гэж эх олонлогийн тодорхой хэсгийг шинжлэх ухааны үндэслэлтэй сонгон судалж, эх олонлогийн шинж чанарыг тооцох статистикийн ажиглалтыг;

3.1.19. “хүртээмжтэй хэлбэр” гэж статистикийн мэдээлэл, үйлчилгээ болон харилцааг хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил тэгш нөхцөлөөр хүлээн авах, ашиглах боломжийг хангасан брайл, аудио, дохионы хэл, хялбаршуулсан текст, цахим хүртээмжийн стандарт хангасан болон бусад хэлбэрийг;

3.1.20. “өгөгдлийн засаглал” гэж статистикийн зорилгоор ашиглах өгөгдлийн эх үүсвэрийг тодорхойлох, бүрдүүлэх, ангилах, стандартчилах, чанарыг хангах, солилцох, ашиглах, хамгаалах, хадгалах, устгах, хариуцагч болон хэрэглэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох удирдлага, зохион байгуулалт, хяналтын цогц үйл ажиллагааг;

3.1.21. “өгөгдлийн шинжилгээ” гэж статистикийн зорилгоор цуглуулсан, олж авсан, нэгтгэсэн өгөгдлийг шинжлэх ухааны арга зүй, статистикийн, мэдээллийн технологийн арга хэрэгслээр боловсруулах, загварчлах, харьцуулах, тайлбарлах, дүгнэлт гаргах, бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хэрэглэгчийн мэдээллийн хэрэгцээнд нийцүүлэн ашиглах үйл ажиллагааг;

3.1.22. “эрх бүхий ажилтан” гэж Үндэсний статистикийн хорооноос тогтоосон журам, эрхийн түвшин, нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангаж, статистикийн зорилгоор өгөгдөл, мэдээлэлд хандах эрх олгогдсон статистикийн байгууллагын ажилтныг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Энэ хууль нь статистикийн үйл ажиллагааг эрхлэх, албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны мэдээлэл боловсруулах, тархаах, статистикийн мэдээлэл цуглуулах, түүнийг гаргаж өгөх үүрэг бүхий хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамаарна.

4.2. Статистикийн зорилгоор энэ хуульд заасан мэдээлэл гаргуулах, мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, мэдээлэл татах ажиллагаанд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Байгууллагын нууцын тухай хуульд заасан зөвшөөрөл авах шаардлагагүй бөгөөд уг ажиллагаа нь зөвхөн энэ хуулийн 16, 17, 18 дугаар зүйлд заасан зорилго, хамгаалалтын нөхцөл, хандалтын бүртгэл, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагын хүрээнд хэрэгжинэ.

4.3. Хүн, хуулийн этгээдээс албан ёсны статистикийн мэдээллийг нэмэх, хасах, өөрчлөх, хувиргах, жишин харьцуулах зэргээр анхдагч агуулгаас өөрөөр албан бус статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

5 дугаар зүйл. Статистикийн үйл ажиллагааны зарчим

5.1.Статистикийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.Албан ёсны статистикийн үйл ажиллагаа нь мэргэжлийн, хараат бус, бие даасан байх;

5.1.2.шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай, мэргэжлийн стандарт, ёс зүйд нийцсэн байх;

5.1.3.статистикийн мэдээллийн арга зүй, эх үүсвэр, нийтлэх хуваарь хэрэглэгчид ойлгомжтой, ил тод байх, хүртээмжтэй байх;

5.1.4.статистикийн мэдээллийг буруу ташаа ашигласан, тайлбарласан, мэдээлэлд алдаа илэрсэн тохиолдолд залруулга, тайлбар хийх;

5.1.5.мэдээллийн чанар, хамрах хугацаа, өртөг, мэдээлэгчийн ачааллыг харгалзан мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох;

5.1.6.мэдээлэгчийн нууцлалыг хангаж, статистикийн өгөгдлийг зөвхөн статистикийн зорилгоор ашиглах;

5.1.7.статистикийн мэдээллийг хуулиар зөвшөөрсөн хэмжээнд нийтэд хүртээмжтэй болгох;

5.1.8.үндэсний статистикийн зохицуулалт, арга зүйн нэгдмэл байдлыг хангах;

5.1.9.олон улсын статистикийн стандарт, ангилал, аргачлалтай нийцсэн байх;

5.1.10.статистикийн олон талт хамтын ажиллагааг дэмжих;

ХОЁРДУГААР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ТОГТОЛЦОО

6 дугаар зүйл.Үндэсний статистикийн тогтолцоо

6.1.Үндэсний статистикийн тогтолцоо нь статистикийн мэдээллийг эрхлэн гаргадаг статистикийн байгууллага, Монголбанк, нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага болон хуульд заасан бусад мэдээлэл хариуцагчаас бүрдэнэ.

6.2.Статистикийн байгууллага нь Үндэсний статистикийн хороо болон холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсөв, статистикийн ажлын ачаалалд үндэслэн байгуулагдсан аймаг, нийслэлийн статистикийн газар, сум, дүүргийн статистикийн хэлтэс, алба, нэгжээс бүрдэж болно.

6.3.Үндэсний статистикийн тогтолцоог Үндэсний статистикийн хороо тэргүүлж, арга зүйн нэгдмэл удирдлага, зохицуулалтаар хангана.

6.4.Үндэсний статистикийн хорооны дэргэд статистикийн арга зүй, ангилал, аргачлал, стандартын уялдааг хангах чиг үүрэг бүхий Арга зүйн орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Үндэсний статистикийн хорооны дарга батална.

6.5.Статистикийн байгууллагын ажилтан нь төрийн захиргааны албан тушаалтан байна.

6.6.Статистикийн байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7 дугаар зүйл. Үндэсний статистикийн хороо, түүний бүрэн эрх

7.1.Үндэсний статистикийн хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.албан ёсны статистикийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;

7.1.2.Үндэсний статистикийн тогтолцоог мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

7.1.3.статистикийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх, саналын төсөл боловсруулж эрх бүхий байгууллага, хууль санаачлагчид уламжлах, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд статистикийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, аргачлалыг батлах;

7.1.4.албан ёсны статистикийн үндсэн үзүүлэлтэд үндэслэн дэд, дэлгэрэнгүй үзүүлэлт, тооллого, судалгааны жагсаалт, жилийн тайлан, төлөвлөгөөг батлах, дунд хугацааны албан ёсны статистикийн хөтөлбөрийг боловсруулж, Үндэсний статистикийн Зөвлөлөөр хэлэлцэн батлуулах;

7.1.5.албан ёсны статистикийн болон захиргааны мэдээллийн аргачлал, ангилал, стандарт, маягт, заавар, албан ёсны статистикийн мэдээллийг нийтлэх, тархаах хуваарийг батлах;

7.1.6.энэ хуулийн 16.4 дүгээр зүйлд заасан журмаар төрийн болон бусад байгууллагын мэдээллийн сан, өгөгдөлд статистикийн зорилгоор хандах, ашиглах, мэдээлэл татах;

7.1.7.мэдээлэгч, төрийн байгууллага, албан тушаалтнаас статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд гаргуулан авах;

7.1.8.статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулах, оролцогч талуудыг арга зүйгээр хангах;

7.1.9.албан ёсны статистикийн мэдээллийг нийтлэх, тархаах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, хэрэглэгчийн санал авах. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн хүртээмжтэй хэлбэрээр тархаах;

7.1.10.статистикийн мэдээлэлд алдаа, буруу тайлбар, буруу хэрэглээ илэрвэл энэ хуульд заасан журмаар залруулга, тайлбар, мэдэгдэл хийх;

7.1.11.статистикийн мэдээллийн чанар, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг батлах;

7.1.12.статистикийн талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

7.1.13.хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн мэдээллийг холбогдох байгууллагатай хамтран гаргаж, Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас хоёр сараас доошгүй хугацааны өмнө Улсын Их Хуралд мэдээлэх;

7.1.14.хуульд заасан бусад бүрэн эрх.

7.2.Үндэсний статистикийн хороо статистикийн үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх, мэдээллийн технологи, өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээний арга хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

7.3.Албан ёсны статистикийн үйл ажиллагааг дунд хугацааны албан ёсны статистикийн хөтөлбөр болон жилийн статистикийн төлөвлөгөөнд үндэслэн хэрэгжүүлнэ.

7.4.Дунд хугацааны албан ёсны статистикийн хөтөлбөрийг улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан таван жилийн хугацаагаар Үндэсний статистикийн хороо боловсруулж, холбогдох журмын дагуу Улсын Их Хурлаар батлуулна.

7.5.Жилийн статистикийн төлөвлөгөөг Үндэсний статистикийн хороо батална.

7.6.Жилийн статистикийн төлөвлөгөөнд арга хэмжээний зорилго, хугацаа, хэрэгжүүлэгч байгууллага, шалгуур үзүүлэлт болон шаардагдах санхүүжилтийн хэрэгцээг тусгана.

7.7.Үндэсний статистикийн хороо үйл ажиллагааны тайлангаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнана.

8 дугаар зүйл. Үндэсний статистикийн зөвлөл

8.1.Үндэсний статистикийн зөвлөл нь үндэсний статистикийн тогтолцооны хараат бус байдал, чанар, арга зүйн уялдаа, төсөв, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд зөвлөх, дүн шинжилгээ хийх чиг үүрэгтэй орон тооны бус зөвлөл байна.

8.2.Зөвлөл нь Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, орон тооны бус 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Үндэсний статистикийн хорооны дарга тэргүүлнэ. Зөвлөлийн орон тооны бус долоон гишүүний 2 гишүүнийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо, 3 гишүүнийг Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Монголбанкаас тус бүр 1 гишүүнийг нэр дэвшүүлж, санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно.

8.3.Зөвлөлийн дарга, гишүүдийг томилоход түүний эдийн засаг, статистик, мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

8.4.Зөвлөлийн гишүүний бүрэн эрх томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно.

8.5.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдааны шийдвэр нь зөвлөмж байна.

8.6.Зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулах бөгөөд гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хурлыг хүчинтэйд тооцно. Санал хураалтыг илээр явуулж, хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.

8.7.Зөвлөл хуралдааныхаа дэг, тов, хэлэлцэх асуудлыг өөрөө тогтоох бөгөөд зөвлөлийн дарга батална.

8.8.Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл гурав, түүнээс дээш гишүүдийн шаардсанаар зарлан хуралдуулна.

8.9.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.9.1.Энэ хуулийн 28.5-д заасан; түүнчлэн үндэсний статистикийн зохицуулалт, системд үзүүлж буй хууль тогтоомж, хэм хэмжээний актын нөлөөллийг жил бүр тооцож, зөвлөмжийг холбогдох бусад төрийн байгууллагад хүргүүлэх;

8.9.2.албан ёсны статистикийн үйл ажиллагааны чанарын үнэлгээ, чанарын дотоод хяналтын тайланд дүн шинжилгээ хийж, зөвлөмж өгөх;

8.9.3.энэ хуулийн 15.1-д заасан албан ёсны статистикийн үндсэн үзүүлэлтэд үндэслэн жил бүрийн статистик мэдээллийн дэд, дэлгэрэнгүй үзүүлэлт, судалгаа, тооллого, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал гаргах;

8.9.4.статистикийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах тогтолцоо, бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад уламжлах;

8.9.5.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны жилийн тайлан, төсөв болон хөрөнгө оруулалтын төсвийн саналыг хэлэлцэж, зөвлөмж өгөх;

8.10.Зөвлөл үйл ажиллагааныхаа тайланг жил бүр гаргаж, энэ хуулийн 7.7-д заасан Үндэсний статистикийн хорооны Улсын Их Хуралд хүргүүлэх тайланд хавсарган хүргүүлнэ.

8.11.Зөвлөл нь албан ёсны статистикийн дунд хугацааны хөтөлбөрийг хэлэлцэн, батална.

9 дүгээр зүйл. Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга

9.1.Үндэсний статистикийн хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар томилно.

9.2.Үндэсний статистикийн хорооны дэд даргыг Үндэсний статистикийн хорооны даргын санал болгосноор Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж, зургаан жилийн хугацаагаар томилно.

9.3.Дарга, дэд даргыг томилоход эдийн засаг, статистикийн, удирдлагын мэдлэг, мэргэшил, мэргэжлийн ёс зүй, ажлын туршлагыг харгалзана.

9.4.Дарга, дэд дарга нь сахилгын шийтгэлгүй, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, ял шийтгэгдэж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

9.5.Дарга, дэд даргын бүрэн эрх дараагийн дарга, дэд дарга томилогдсоноор дуусгавар болно.

9.6.Дарга, дэд даргыг бүрэн эрхийн хугацаа дууссан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон, эсхүл өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд чөлөөлнө.

9.7.Үндэсний статистикийн хорооны даргын түр эзгүйд түүний албан үүргийг дэд дарга гүйцэтгэнэ.

10 дугаар зүйл. Үндэсний статистикийн хорооны даргын бүрэн эрх

10.1.Үндэсний статистикийн хорооны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.Үндэсний статистикийн хороог тэргүүлж, дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

10.1.2.Үндэсний статистикийн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

10.1.3.Үндэсний статистикийн хорооны Тамгын газар, дотоод аудитын нэгж, аймаг, нийслэлийн статистикийн газар, сум, дүүргийн статистикийн хэлтэс, албаны даргыг томилж, чөлөөлөх;

10.1.4.арга зүйн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

10.1.5.статистикийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

10.1.6. Үндэсний статистикийн хорооны баталсан бодлого, стандарт, аргачлал, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

10.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

10.2.Үндэсний статистикийн хорооны дарга нь бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

11 дүгээр зүйл. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын бүрэн эрх

11.1.Үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга нь төсвийн шууд захирагч байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

11.1.1.Үндэсний статистикийн хорооны даргатай зөвшилцөн ажилтныг томилох, чөлөөлөх;

11.1.2.батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах, тайлагнах;

11.1.3.үндэсний статистикийн зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах;

11.1.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

11.2.Үндэсний статистикийн хорооны тамгын газрын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн статистикийн байгууллагын эрх, үүрэг

12.1.Аймаг, нийслэлд статистикийн газар ажиллана. Аймаг, нийслэлийн статистикийн газар үйл ажиллагаагаа Үндэсний статистикийн хорооны даргад тайлагнана.

12.2.Аймаг, нийслэлийн статистикийн газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.2.1.Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, заавар, төлөвлөгөө, шийдвэрийг хэрэгжүүлэх;

12.2.2.албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах, хянах, дамжуулах, анхан шатны боловсруулалт хийх, тооллого, судалгааг орон нутагт зохион байгуулах;

12.2.3.мэдээллийн чанар, нууцлал, аюулгүй байдлыг хангах.

12.3.Аймаг, нийслэлийн статистикийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсөв, статистикийн ажлын ачааллыг үндэслэн Үндэсний статистикийн хорооны дарга батална.

12.4.Аймаг, нийслэлийн статистикийн газрын дарга нь Төсвийн шууд захирагч байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1.статистикийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

12.4.2.статистикийн газрын харьяа хэлтэс, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

12.4.3.Үндэсний статистикийн хорооны даргатай зөвшилцөн хэлтэс, албаны ажилтныг томилж, чөлөөлөх;

12.4.4.батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах.

12.5.Аймаг, нийслэлийн статистикийн газрын дарга ажлаа Үндэсний статистикийн хорооны даргад хариуцан тайлагнана.

12.6.Аймаг, нийслэлийн статистикийн газрын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.

13 дугаар зүйл. Сум, дүүргийн статистикийн хэлтэс, алба, нэгж

13.1.Сум, дүүрэгт статистикийн хэлтэс, алба, эсхүл нэгж байгуулах асуудлыг статистикийн ажлын ачаалал, хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, төсвийн боломж, бүсчилсэн хөгжлийн бодлого болон холбогдох хууль тогтоомжид үндэслэн шийдвэрлэнэ.

13.2.Сум, дүүргийн статистикийн хэлтэс, алба, нэгж нь мэргэжлийн хувьд аймаг, нийслэлийн статистикийн газарт харьяалагдана.

13.3.Сумын түвшинд статистикийн алба, нэгж байгуулахдаа тухайн орон нутгийн хүн амын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, эдийн засгийн идэвхжил, тооллого, судалгааны давтамж, бүсчилсэн хөгжлийн бодлогод эзлэх байр суурь, статистикийн ажлын ачааллыг харгалзана.

13.4.Сум, дүүргийн статистикийн хэлтэс, алба, нэгжийн бүтэц, орон тоо, ачааллын ангилал, аргачлалыг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсөв, статистикийн ажлын ачааллыг үндэслэн Үндэсний статистикийн хороо батална.

13.5.Статистикийн хэлтэс, алба нь энэ хуулийн 12.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, оролцоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭЛБЭР, ЭХ ҮҮСВЭР, САН, НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

14 дүгээр зүйл. Статистикийн мэдээллийн хэлбэр

14.1.Статистикийн мэдээлэл нь албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны мэдээлэл гэсэн хэлбэртэй байна.

14.2.Албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо болон энэ хуулийн 6.1-д заасан үндэсний статистикийн тогтолцооны байгууллага энэ хуулийн 7.1.5-д заасан аргачлал, үзүүлэлт, хуваарийн дагуу эрхлэн гаргана.

14.3.Захиргааны мэдээллийг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хуульд заасан мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүргийн хүрээнд бүрдүүлж, статистикийн зорилгоор ашиглуулахдаа Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, ангилал, чанарын шаардлага, зааврыг баримтална.

14.4.Үндэсний статистикийн хороо бусад байгууллагаас эрхлэн гаргах албан ёсны статистикийн мэдээллийн үндсэн ба дэд үзүүлэлт, арга зүйн шаардлагыг тогтоож болно.

15 дугаар зүйл. Албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт

15.1.Албан ёсны статистикийн мэдээлэлд хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглал, салбар дундын болон Үндэсний статистикийн хорооноос тогтоосон бусад статистикийн үзүүлэлт хамаарна.

15.2.Албан ёсны статистикийн мэдээлэл нь баталсан арга зүй, стандарт, ангилалд нийцсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, харьцуулах боломжтой байна.

15.3.Албан ёсны статистикийн мэдээллийг урьдчилан баталж, олон нийтэд мэдээлсэн нийтлэх хуваарийн дагуу нийтэлнэ.

15.4.Хүн ам, орон сууцны улсын тооллоготой холбоотой харилцааг тусгай хуулиар зохицуулна.

15.5.Энэ хуулийн 15.1-д заасан хүрээнд хамаарах үндсэн болон дэд үзүүлэлт, тэдгээрийн аргачлал, эх үүсвэр, эрхлэн гаргах байгууллага, мэдээлэл гаргах давтамж, нийтлэх хугацааг албан ёсны статистикийн хөтөлбөрт тусгана.

15.6.Үндэсний статистикийн байгууллага нь албан ёсны статистик мэдээллийн чанарыг тогтоосон шалгуур, мэргэжлийн үнэлгээний аргачлалын дагуу тогтмол үнэлж, чанарыг сайжруулах арга хэмжээг энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

16 дугаар зүйл. Статистикийн мэдээллийн сан, өгөгдөлд хандах эрх

16.1.Статистикийн мэдээллийн нэгдсэн санг Үндэсний статистикийн хороо үүсгэж, эрхлэн хөтөлнө.

16.2.Төрийн байгууллага, албан тушаалтан, хуульд заасан мэдээлэл хариуцагч нь статистикийн мэдээллийн нэгдсэн санд оруулах албан ёсны, бодитой, бүрэн, чанартай мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос тогтоосон хугацаа, хэлбэрээр шилжүүлэн өгөх үүрэгтэй.

16.3.Үндэсний статистикийн хороо болон статистикийн байгууллагын эрх бүхий ажилтан статистикийн зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн

27.2, 27.3, 27.4-т заасан болон хуульд заасан бусад мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, нэгтгэх, мэдээлэл татах эрхтэй.

16.4.Энэ зүйлийн 16.3-т заасан мэдээллийн санд хандах, ашиглах, мэдээлэл татах журам, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын нийтлэг шаардлагыг Засгийн газар батална. Үндэсний статистикийн хороо уг журмын хэрэгжилтийг зохион байгуулахад шаардлагатай дотоод заавар, техник, арга зүйн шаардлагыг баталж болно.

16.5.Мэдээллийн сан эрхэлж, хариуцаж байгаа байгууллага, хуулийн этгээд нь статистикийн зорилгоор хандах, ашиглах, мэдээлэл татах нөхцөлийг бүрдүүлэх, техникийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

16.6.Албан ёсны статистикийн мэдээлэл бий болгох явцад бүрдсэн анхдагч өгөгдлийг хувь хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар таних боломжгүй болгосон, нууцлалыг хангасан хэлбэрээр зөвшөөрөгдсөн судлаачид аюулгүй судалгааны орчинд зөвхөн эрдэм шинжилгээ, бодлогын судалгааны зорилгоор ашиглуулж болно.

16.7.Анхдагч өгөгдөл ашиглуулах журам, судлаачийг бүртгэх, баталгаажуулах шалгуур, өгөгдөлд нэвтрэх эрхийн түвшин, хандалтын бүртгэл, гаралтын хяналт, аудит, хяналт-шинжилгээ, хариуцлагын механизмыг Үндэсний статистикийн хорооны дарга батална.

16.8.Мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, мэдээлэл татах ажиллагааг хандалтын эрх, зориулалт, хугацаа, өгөгдлийн төрөл, боловсруулалтын үйлдэл, гаралтын хяналт, хариуцагчийг тодорхойлох бүртгэлээр баримтжуулна.

16.9.Мэдээлэл хариуцагч статистикийн зорилгоор ашиглуулах өгөгдлийн мета өгөгдөл, ангилал, код, өгөгдлийн бүтэц, хамрах хүрээ, шинэчлэлт, өөрчлөлтийн талаар Үндэсний статистикийн хороонд тогтоосон хугацаанд мэдээлнэ.

16.10.Мэдээлэл хариуцагчтай байгуулах өгөгдөл солилцох гэрээ, протоколд өгөгдлийн төрөл, давтамж, формат, хандалтын эрх, нууцлал, мэдээллийн аюулгүй байдал, хариуцлага, зөрчил мэдэгдэх болон өөрчлөлтийн мэдээлэл өгөх нөхцөлийг тусгана.

17 дугаар зүйл. Статистикийн мэдээллийн нууцлал, мэдээлэгчийн хамгаалалт

17.1.Статистикийн зорилгоор цуглуулсан, дамжуулсан, нэгтгэсэн, боловсруулсан мэдээлэлд агуулагдах мэдээлэгч, хүн, хуулийн этгээдийн хууль тогтоомжоор хамгаалагдсан нууцыг мэдээлэл хариуцагч чандлан хадгална.

17.2.Статистикийн үйл ажиллагаанд оролцогч нь нууцлал хадгалах, задруулахгүй байх үүрэгтэй танилцаж, энэ хуулийн 7.1.11-д заасан журам болон Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 4.2.2-т заасны дагуу баталгаа гаргасан байна.

17.3.Хуульд өөрөөр заагаагүй бол статистикийн зорилгоор цуглуулсан мэдээллийг статистикийн бус зорилгоор бусдад шилжүүлэх, дамжуулах, нийтлэх, ил болгох, дахин ашиглах, өөрчлөх, задруулахыг хориглоно.

17.4.Мэдээлэгчийг шууд болон шууд бусаар таних боломжтой мэдээллийг зөвхөн нууцлалыг хангасан, нэгтгэсэн, таних боломжгүй хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

17.5.Статистикийн анхдагч өгөгдлийг захиргааны, эрүүгийн, татварын болон бусад хяналт шалгалт, хувь хүн, хуулийн этгээдийн талаар шийдвэр гаргах ажиллагаанд ашиглахыг хориглоно.

17.6.Хуульд өөрөөр заасан үндэслэлээр нууц мэдээллийг шилжүүлэн авсан этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас мэдээлэгчийн нууц задарсан бол түүнээс үүсэх үр дагаврыг мэдээллийг шилжүүлэн авсан этгээд хариуцна.

17.7.Мэдээлэгч өөрийн мэдээллийн нууцлал алдагдсан гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй.

18 дугаар зүйл. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

18.1.Статистикийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.2, 18.6, Кибер аюулгүй байдлын тухай 17.1-д заасан журмаар хангуулна.

18.2.Статистикийн байгууллага нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах техник, программ хангамжийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

18.3.Мэдээллийн аюулгүй байдал алдагдах нөхцөл үүссэн, зөрчил гарсан тохиолдолд статистикийн байгууллага холбогдох хууль тогтоомжид заасан журмаар мэдэгдэх, бүртгэх, таслан зогсоох, сэргээх, аудитын мөрийг хадгалах, хариуцлага тооцуулах арга хэмжээ авна.

18.4.Мэдээлэгчид мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын хамгаалалтын талаар урьдчилан мэдээлэл өгсөн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ, БАТАЛГАА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

19 дүгээр зүйл. Статистикийн үйл ажиллагааны хараат бус байдлын баталгаа

19.1.Үндэсний статистикийн тогтолцооны байгууллага, түүний ажилтан статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мэргэжил, арга зүй, үйл ажиллагаа, төсвийн хувьд хүрэлцэхүйц, аливаа этгээдээс хараат бус байна.

19.2.Албан ёсны статистикийн үйл ажиллагаа, түүнд холбогдох мэргэжлийн шийдвэрийг энэ хуульд зааснаас өөр байгууллага, албан тушаалтан эрхлэхийг хориглоно.

19.3.Статистикийн байгууллага хэрэглэгчид өгөөжтэй, мэдээлэгчид ачаалал, зардал бага арга, хэлбэрийг харгалзан статистикийн мэдээллийн эх үүсвэрээ мэргэжлийн үндэслэлээр өөрөө тодорхойлно.

19.4.Статистикийн байгууллагын мэргэжлийн шийдвэр, аргачлал, тооцоолол, нийтлэх хугацаанд улс төр, захиргаа, эдийн засаг, бусад ашиг сонирхлын үндэслэлээр нөлөөлөхийг хориглоно.

20 дугаар зүйл. Хөндлөнгийн оролцоо, мэдээллийг урьдчилан авах болон бусад хориглох зүйл

20.1.Статистикийн үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

20.2.Статистикийн байгууллагад мэдээллийн эх үүсвэрийг нэрлэн заах, тулгах, сонгон хэрэглэхийг шаардахыг хориглоно.

20.3.Албан ёсны статистикийн мэдээллийг нийтлэхээс өмнө аливаа төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэнд урьдчилан олгохыг хориглоно.

20.4.Албан ёсны статистикийн мэдээллийг нийтлэх хуваарийг зөрчиж мэдээлэх, урьдчилан эсхүл ялгавартай байдлаар түгээхийг хориглоно.

20.5.Статистикийн мэдээллийн үзүүлэлт, арга зүй, аргачлал, агуулга, тоон мэдээллийг зориуд өөрчлөх, өөрчлүүлэхээр нөлөөлөх, нийтлэх хугацааг үндэслэлгүйгээр хойшлуулах, саатуулахыг хориглоно.

20.6.Үндэсний аюулгүй байдал, гамшиг, онцгой нөхцөл байдал, эсхүл хуульд тусгайлан заасан үндэслэлээр мэдээлэлтэй урьдчилан танилцах шаардлага гарсан тохиолдолд уг мэдээллийг зөвхөн хуульд заасан эрх бүхий байгууллагад тогтоосон журмын дагуу танилцуулж болно. Энэ нь статистикийн агуулга, арга зүй, нийтлэх шийдвэрт нөлөөлөх үндэслэл болохгүй.

20.7.Статистикийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

20.7.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө ашиглан өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох;

20.7.2.статистикийн үйл ажиллагааны явцад мэдсэн нууц, хамгаалагдсан мэдээллийг задруулах;

20.7.3.албан ажлын материал, техник хэрэгслийг өөр зориулалтаар ашиглах;

20.7.4.боловсруулалтын шатанд байгаа, албан ёсоор нийтлээгүй статистикийн мэдээлэл, судалгааны дүн, тооцооллыг шаардах, авах, тархаах.

20.8.Статистикийн байгууллага, түүний ажилтан мэдээлэгчийн өгөх мэдээллийн агуулгыг зориуд нэрлэн заах, өөр агуулга санал болгох, гуйвуулах, засварлах, бусад байдлаар нөлөөлөхийг хориглоно.

20.9.Статистикийн мэдээллийг улс төрийн зорилго, агуулгаар боловсруулах, тархаах, улс төрийн сонгуульд тодорхой нэр дэвшигчийг дэмжих, эсхүл дэмжихгүй байх зорилгоор статистикийн үйл ажиллагааг эрхлэх, мэдээлэл тархаахыг хориглоно.

21 дүгээр зүйл. Ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт

21.1. Үндэсний статистикийн тогтолцооны байгууллагын ажилтан статистикийн үйл ажиллагаанд оролцох үед ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болбол энэ талаар даруй мэдэгдэх үүрэгтэй.

21.2. Статистикийн мэдээлэл, түүний тоон болон бусад агуулгыг урьдчилан нотлох, батлах зорилгоор статистикийн мэдээлэл боловсруулахыг хориглоно.

21.3. Ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг тухайн статистикийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан авна.

22 дугаар зүйл. Статистикийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

22.1. Статистикийн байгууллагын төсөв нь энэ хуулийн 7.1.4-т заасан үзүүлэлт, тооллого, судалгаа, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.

22.2. Үндэсний статистикийн хорооноос хүргүүлсэн статистикийн судалгаа, тооллогын төсвийн саналыг үндэслэлгүйгээр бууруулахыг хориглоно.

22.3. Статистикийн байгууллагын ажилтны албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгох журам, цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал тогтооно.

23 дугаар зүйл. Статистикийн улсын байцаагч, түүний эрх, үүрэг

23.1. Статистикийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Үндэсний статистикийн хорооны шийдвэрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, мэдээлэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, чанарын хяналт хийх чиг үүрэг бүхий улсын байцаагч ажиллана. Үндэсний статистикийн хороонд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

23.2. Үндэсний статистикийн хорооны дарга улсын ерөнхий байцаагч байх бөгөөд түүний шийдвэрээр улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг томилж, чөлөөлнө.

23.3. Статистикийн улсын байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлж мөн дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.3.1. статистикийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, статистикийн тухай хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулах;

23.3.2. судалгаа, хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлан, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

23.3.3. хийсэн хяналт шалгалтын бодит байдлыг бүрэн хариуцах;

23.3.4. зөрчилд шийтгэл ногдуулах тухай өөрийн болон Үндэсний статистикийн хорооноос гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах;

23.3.5. шалгалтын дүнг мэдээлэх, илэрсэн зөрчил, дутагдлын талаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавьж арилгуулах;

23.3.6. өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн мэдээ, тайлан нь дутуу, алдаатай бол холбогдох этгээдээс тайлбар гаргуулан авах, анхан шатны бүртгэлтэй тулгаж, магадлах.

23.3.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

23.4. Статистикийн улсын байцаагчийн хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд өгсөн үүрэг, тавьсан шаардлагыг холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

23.5. Статистикийн улсын байцаагч нь түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн шаардах хуудас, акт, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

23.6. Албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, хувийн хэрэгцээнд үнэмлэх, тэмдэг ашиглахыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР, ЗАЛРУУЛГА

24 дүгээр зүйл. Статистикийн мэдээллийн чанарын хяналт, залруулга

24.1. Үндэсний статистикийн хороонд статистикийн мэдээллийг боловсруулахдаа баталсан арга зүй, аргачлал, ангилал, дүрэм, журам, зааварт нийцсэн эсэх, албан ёсны статистикийн мэдээлэл чанарын шалгуур, стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт тавих үндсэн бүтцийн нэгж ажиллана.

24.2. Чанарын хяналтыг Үндэсний статистикийн хорооноос баталсан удирдамжийн дагуу жилд нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр хэрэгжүүлнэ.

24.3. Албан ёсны статистикийн мэдээллийг нийтлэхээс өмнө чанарын хяналтын санал, дүгнэлтийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан байна.

24.4. Нийтэд тархаасан албан ёсны статистикийн мэдээлэл баталсан аргачлал, чанарын шаардлагад нийцээгүй нь тогтоогдвол үндэслэл, шалтгааныг ил тод тайлбарлаж, залруулга, мэдэгдлийг нийтлэх хуваарь, тархаалтын сувгаар нийтэд мэдээлнэ.

24.5. Чанарын хяналтын тайлан, зөвлөмжийг Үндэсний статистикийн зөвлөлд танилцуулна.

24.6.Албан ёсны статистикийн мэдээлэлд алдаа гарсан, буруу залруулга хийсэн, эсхүл чанарын шаардлага зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг энэ хуулийн 29 дүгээр зүйл болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

25 дугаар зүйл. Статистикийн мэдээлэгч, түүний эрх, үүрэг

25.1.Энэ хуулийн 7.1.4, 15.1-д заасан үзүүлэлт, тооллого, судалгаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь статистикийн зорилгоор цуглуулах өөрт байгаа мэдээллийг статистикийн байгууллага, түүний ажилтанд гаргаж өгөх үүрэгтэй.

25.2.Мэдээлэгчээс цуглуулах мэдээллийг ямар үзүүлэлт, тооллого, судалгаанд ашиглах, мөн мэдээллийн нууцлал, хамгаалалтын нөхцөлийг урьдчилан танилцуулсан байна.

25.3.Мэдээлэгч дараах эрхтэй:

25.3.1.статистикийн аль үзүүлэлт, тооллого, судалгаанд хамрагдаж буйг мэдэх, танилцах;

25.3.2.мэдээлэгчийн эрх, үүрэг болон мэдээллийн нууцлал, хамгаалалтын талаар мэдээлэл авах;

25.3.3.энэ хуульд заасан эрх нь зөрчигдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах;

25.3.4.статистикийн үзүүлэлт, аргачлалыг боловсронгуй болгох талаар санал гаргах;

25.3.5.хуульд өөрөөр заагаагүй бол батлаагүй буюу зөвшөөрөөгүй үзүүлэлт, аргачлалаар мэдээлэл гаргаж өгөхөөс татгалзах;

25.3.6.Үндэсний статистикийн тогтолцооны байгууллагаас гаргасан мэдээлэл, судалгааны нэгдсэн дүнтэй танилцах.

25.4.Мэдээлэгч дараах үүрэгтэй:

25.4.1.статистикийн мэдээлэл, судалгаа гаргахад шаардагдах анхдагч бүртгэлийг хөтлөх;

25.4.2.статистикийн мэдээллийг тогтоосон хэлбэр, хугацаанд бодитой, бүрэн гаргаж өгөх. Хөгжлийн бэрхшээлтэй мэдээлэгчийн хувьд мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг түүнд тохирсон хүртээмжтэй хэлбэр, боломжит зохицуулалтаар хангаж зохион байгуулна;

25.4.3.улсын тооллого, түүвэр судалгаанд хамрагдах;

25.4.4.албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд хүргүүлэх;

25.4.5.мэдээллийн сан эрхэлж байгаа мэдээлэл хариуцагч бол энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, мэдээлэл татах нөхцөлийг бүрдүүлэх.

25.5.Мэдээлэгч энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

26 дугаар зүйл. Статистикийн мэдээлэл хэрэглэгчийн эрх, үүрэг

26.1.Албан ёсны статистикийн мэдээллийг хүлээн авч, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага статистикийн мэдээллийн хэрэглэгч байна.

26.2.Хэрэглэгч энэ хуульд заасан журмаар статистикийн мэдээлэл ашиглах, статистикийн мэдээллийн хэрэгцээ, арга зүй, ангилал, үзүүлэлт, тооллого, судалгааны талаар санал, хүсэлт гаргах, нээлттэй мэдээлэлтэй танилцах, өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

26.3.Хэрэглэгч энэ хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөх, статистикийн мэдээллийг нийтэд түгээх, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, тайлан, тайлбар, танилцуулгад ашиглахдаа эх сурвалжийг дурдах, баталсан буюу зөвшөөрснөөс бусад үзүүлэлтийг гаргуулахыг шаардахгүй байх үүрэгтэй.

26.4.Хэрэглэгч энэ хуульд заасан үүргээ зөрчиж бусдад хохирол учруулсан бол хохирлыг өөрөө хариуцна.

27 дугаар зүйл. Статистикийн үйл ажиллагааны талаар Засаг даргын оролцоо

27.1.Статистикийн үйл ажиллагааны талаар бүх шатны Засаг дарга дараах үүргийг хүлээнэ:

27.1.1.тухайн орон нутгийн нэгжид албан ёсны статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа статистикийн газар, нэгжийг нутгийн захиргааны төв байранд байрлуулж, ажиллах нөхцөлөөр хангах;

27.1.2.статистикийн тооллого, судалгаанд техник, зохион байгуулалт, ажиллах хүч, мэдээллийн туслалцааг үзүүлэх;

27.1.3.тооллого, судалгааны ажлыг зохион байгуулах, оролцох, энэ талаар харьяалах доод шатны Засаг дарга, албан тушаалтанд үүрэг, чиглэл, даалгавар өгөх;

27.1.4.статистикийн зорилгоор энэ хуульд заасан журмаар Үндэсний статистикийн хорооноос өгөгдсөн үүрэг, чиглэлийг биелүүлэх.

27.2.Засаг дарга энэ хуульд зааснаас өөр чиг үүрэг, даалгавар, чиглэл өгөх, статистикийн байгууллагын дарга, ажилтныг статистикийн үйл ажиллагаанд үл хамаарах ажил, арга хэмжээнд дайчлахыг хориглоно.

27.3.Гамшиг, онцгой байдал, хуульд тусгайлан заасан үндэслэлээр улсын хэмжээний дайчилгаа зарласан тохиолдолд энэ зүйлийн 27.2 дахь хэсэг хамаарахгүй бөгөөд статистикийн үндсэн чиг үүргийн тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

28 дугаар зүйл. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн оролцоо

28.1.Төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд өөрийн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд захиргааны мэдээллийг бүрдүүлж, энэ хуульд заасан журмаар статистикийн байгууллагад гаргаж өгнө.

28.2.Төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох хууль тогтоомж, батлагдсан бүтэц, орон тоо, төсвийн хүрээнд шаардлагатай бол салбарын статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, Үндэсний статистикийн хороог мэдээллээр хангах чиг үүргийг нэгж, эсхүл статистикийн асуудал хариуцсан албан тушаалтанд хариуцуулж болно.

28.3.Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд дараах үүрэгтэй:

28.3.1.Үндэсний статистикийн хорооноос тогтоосон хугацаанд албан ёсны болон захиргааны мэдээллийг цуглуулж, боловсруулж, статистикийн байгууллагад шилжүүлэх;

28.3.2.захиргааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, шилжүүлэхдээ энэ хууль, баталсан аргачлал, ангилал, зааврыг баримтлах;

28.3.3.мэдээлэл, судалгаа, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

28.3.4.өөрийн цуглуулж, боловсруулж, шилжүүлсэн мэдээллийн бодит байдал, иж бүрдэл, нууцлал, аюулгүй байдлыг хангах;

28.3.5. өөрийн эрхэлж, хариуцаж байгаа мэдээллийн санд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан журмаар статистикийн зорилгоор хандах, ашиглах, мэдээлэл татах нөхцөлийг бүрдүүлэх;

28.3.6.статистикийн мэдээллийн чанарыг хангаж ажилласан тайлан, холбогдох мэдээллийг тухайн байгууллагын статистик, судалгаа хариуцсан нэгж, эсхүл албан тушаалтнаар дамжуулан тогтоосон журмын дагуу ирүүлэх.

28.4.Бусад төрийн байгууллага Үндэсний статистикийн хорооноос тогтоосон албан ёсны статистик мэдээллийн үндсэн ба дэд үзүүлэлтэд үндэслэн холбогдох статистикийн мэдээллийг энэ хуульд заасан журмаар гаргаж, Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

28.5.Үндэсний статистикийн зохицуулалт, системийг боловсронгуй болгох, мэдээллийн олон эх үүсвэр ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд бусад төрийн байгууллага дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД

29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд зөрчлийн шинж, үр дагаварт нь нийцүүлэн Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан сахилгын болон бусад хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан нууцлал, 18 дугаар зүйлд заасан мэдээллийн аюулгүй байдал, 20 дугаар зүйлд заасан хориглосон үйлдлийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.3.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан мэдээллийн сан, өгөгдөлд статистикийн зорилгоор хандах, ашиглах, мэдээлэл татах нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй мэдээлэл хариуцагчид холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.4.Энэ хууль зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан журмаар нөхөн төлүүлнэ.

30 дугаар зүйл. Шилжилтийн зохицуулалт

30.1.Үндэсний статистикийн хороо болон Засгийн газар энэ хуульд нийцүүлэх шаардлагатай дагалдах хууль, дүрэм, журам, шийдвэрийн жагсаалт, хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.

30.2.Энэ хууль хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд одоо мөрдөж байгаа Статистикийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт энэ хуульд харшлахгүй хэмжээнд үйлчилнэ.

30.3.Энэ хуулийн 16.4, 16.7-д заасан журам, шаардлага, заавар болон мэдээллийн сангийн хандалт, нууцлал, аюулгүй байдлын зохицуулалтыг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор батална.

30.4.Дунд хугацааны албан ёсны статистикийн хөтөлбөр батлагдах хүртэл одоо мөрдөж байгаа статистикийн төлөвлөгөө, үзүүлэлт, аргачлал, мэдээлэл гаргах хуваарь энэ хуульд харшлахгүй хэмжээнд үргэлжлэн үйлчилнэ.

30.5.Мэдээллийн сан, өгөгдөлд хандах, ашиглах, мэдээлэл татах техникийн холболт, мета өгөгдлийн жагсаалт, өгөгдөл солилцох гэрээ, протоколыг Үндэсний статистикийн хороо холбогдох мэдээлэл хариуцагчтай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

31 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 3.3, 7.8, 13.10 дахь хэсэг нэмсүгэй:

“3.3. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 28 дугаар зүйлийн 28.1-д заасан статистикийн зорилгоор мэдээлэл гаргаж өгөх үүрэгтэй хүн, хуулийн этгээдээс мэдээлэл гаргуулахад энэ хуульд заасан зөвшөөрөл авах харилцаа хамаарахгүй.

7.8. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан шаардлагыг хангуулж статистикийн зорилгоор ашиглуулна.

13.10. Энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.4-д заасан мэдээллийн санд статистикийн зорилгоор хандах, ашиглах, мэдээлэл татахад зөвшөөрөл шаардахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай 22.1.23, 58.1.14 дэх заалт нэмсүгэй:

“22.1.23.хууль тогтоомжид заасны дагуу албан ёсны статистикийн мэдээллийг гаргах.

58.1.14. хууль тогтоомжид заасны дагуу албан ёсны статистикийн мэдээллийг гаргах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“34.2.Монголбанк нь Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу мөнгө, зээл, хадгаламж, банкнуудын тоймын талаарх албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргана.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19 дэх заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“8.1.19.Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, мэдээлэх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.19 дэх заалт нэмсүгэй:

15.1.19 “Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу байгаль орчны салбарын албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, мэдээлэх;”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.19 дэх заалтын дугаарыг “15.1.20” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь заалтын “статистикийг” гэснийг “албан ёсны статистикийн мэдээллийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.1.6 дахь заалт нэмсүгэй:

“Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, мэдээлэх;”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.6 дахь заалтын дугаарыг “36.1.7” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсанаар нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

“6.....Санхүүгийн зохицуулах хороо нь Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үнэт цаасны зах зээл, брокер, дилер, биржийн албан ёсны статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, ирүүлэх, мэдээлэх.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.8.4 дэх заалт

8.8.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу нэгдсэн албан ёсны статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, мэдээлэх;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс,” гэж, “албан тушаал” гэсний дараа “сумын статистикийн асуудал хариуцсан ажилтан” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтын “байцаагч,” гэсний дараа “статистикийн улсын байцаагч,” гэж, 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “Үндэсний статистикийн хороо,” гэсний дараа “аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэс, сумын статистикийн алба” гэж, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийн “албан хаагч” гэсний дараа, статистикийн байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг **Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/** хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.14, 7.1.15 дахь заалт нэмсүгэй:

“7.1.14.хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд статистикийн захиргааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, Үндэсний статистикийн хороог мэдээллээр хангах;

7.1.15.хуулиар нийгэм, санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн яамд Статистикийн тухай хуулийн 14.2-т заасан журмын дагуу салбарын албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны баталсан үзүүлэлт, хугацаанд эрхлэн гаргах, мэдээлэх;

2 дугаар зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.6.13 дахь заалт нэмсүгэй:

“9.6.13.салбарын хэмжээнд эрхэлж, хариуцаж байгаа мэдээллийн санд статистикийн байгууллага, ажилтнаас зөвхөн статистикийн зорилгоор холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хандах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл татахад дэмжлэг үзүүлэх;

3 дугаар зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “батална.” гэсний дараа “Яамны зохион байгуулалтын бүтцэд салбарын статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, энэ талаарх мэдээллээр Үндэсний статистикийн хороог хангах үүрэг бүхий нэгж байж болно” гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтын дугаарыг “7.1.16” гэж, 9 дүгээр зүйлийн 9.6.13 дахь заалтын дугаарыг “9.1.14” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.10 дахь заалт нэмсүгэй:

“7.1.10.хуулиар хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд статистикийн захиргааны мэдээллийг цуглуулах, боловсруулах, Үндэсний статистикийн хороог мэдээллээр хангах;”

2 дугаар зүйл.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.3.11 дэх заалт нэмсүгэй:

“8.3.11.агентлагийн эрхэлж, хариуцаж байгаа мэдээллийн санд статистикийн байгууллага, ажилтнаас зөвхөн статистикийн зорилгоор холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хандах, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл татахад дэмжлэг үзүүлэх;”

3 дугаар зүйл.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын дугаарыг “7.1.11” гэж, 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалтын дугаарыг “8.3.12” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

20 ... оны .. дугаар
сарын .. -ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр баталсан Статистикийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8.2-т заасан зөвлөлийн орон тооны бус гишүүд, 9.1-д заасан Үндэсний статистикийн хорооны даргыг уг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор нэр дэвшүүлж, санал болгосноор Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж, томилно. Үндэсний статистикийн хорооны дарга томилогдсноос хойш 30 хоногийн дотор тус хорооны дэд даргыг мөн хуулийн 9.2-т зааснаар санал болгож, энэ зүйлд заасан журмаар томилно.

2 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн дарга, гишүүд, тамгын газрын дарга томилогдох хүртэлх хугацаанд өмнө нь томилогдсон дарга, гишүүд, ерөнхий менежер бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан дарга, гишүүд, тамгын газрын дарга томилогдсноор өмнөх дарга, гишүүд, ерөнхий менежерийг чөлөөлсөнд тооцно.

3 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон 2026 оны үйл ажиллагааны тайланг Статистикийн тухай хууль (1997 он)-д заасан үзүүлэлтийн дагуу Улсын Их Хуралд тайлагнана.

4 дүгээр зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан аймаг, нийслэлийн статистикийн газар, сум, дүүргийн статистикийн хэлтэс, албыг байгуулах, тэдгээрийн даргыг томилох хүртэл хугацаанд Статистикийн тухай хууль (1997 он)-д зааснаар байгуулагдсан газар, хэлтэс, алба, тэдгээрийн дарга бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

5 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 9.1-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргыг томилсноос хойш 120 хоногийн дотор дараах шийдвэрийг гаргана.

5.1. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6.4-т заасан арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

5.2. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 12.1-д заасан аймаг, нийслэлийн статистикийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаар, 12.3-д заасан үйл ажиллагааны нийтлэг журмыг тогтоох;

5.3. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 13.1-д заасан сум, дүүрэгт статистикийн хэлтэс, эсхүл тусгайлсан алба байгуулах, тэдгээрийн бүтэц, орон тооны дээд хязгаар, үйл ажиллагааны нийтлэг журмыг тогтоох;

6 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор цахим хөгжил, харилцаа холбооны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтарч уг хуулийн 16.2-т заасан журмыг Үндэсний статистикийн хороо, Тагнуулын ерөнхий газрын саналыг авч, төслийг боловсруулж, өргөн мэдүүлснээр Засгийн газар батална. Энэ зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх бэлтгэл

ажлыг Үндэсний статистикийн хороо болон хариуцаж буй мэдээллээ солилцох байгууллага, албан тушаалтан 2027 оны 08 дугаар сарын 15-ны дотор хангуулж, гэрээ байгуулж, 2027 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 120 хоногийн дотор уг хуулийн 22.2-т заасан ангилал, зэрэглэл, цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгох журмыг Үндэсний статистикийн хорооны өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

8 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагуу Үндэсний статистикийн хорооны бүтцэд өөрчлөлт орох, түүнчлэн энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар статистикийн газар, хэлтэс, албыг шинээр болон өөрчлөн байгуулах, 7 дугаар зүйлд зааснаар зэрэг зиндаа өөрчлөгдсөн нь Статистикийн тухай хууль (1997 он)-д зааснаар томилогдон ажиллаж буй төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Зэрэг зиндаа нь өөрчлөгдсөн төрийн албан хаагч Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22.2, Улсын Их Хурлаас тогтоосон зэрэг зиндаа, Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд хангана.

9 дүгээр зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлийн 6.7, 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.3, 7.3.8, 7.5, 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.3, 22 дугаар зүйлийн 22.1, 32 дугаар зүйлийн 32.2.7 дахь заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

10 дугаар зүйл. Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болж дагаж мөрдөхөөс өмнө боловруулагдаж эхэлсэн статистик мэдээллийг Статистикийн тухай хууль (1997 он)-д заасан журмаар дуусгаж, нийтэд тархаана.

11 дүгээр зүйл. Статистикийн байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчийн цалин, нэмэгдлийг 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд 2026 оны төсвийн жил дуусах хүртэл хугацаанд мөрдөнө.

12 дугаар зүйл. Энэ хуулийг Статистикийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг